



ТЭЭВЭР ХӨГЖЛИЙН БАНКНЫ ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХАРААТ БУС ГИШҮҮНИЙ 2022 ОНЫ 1 ДҮГЭЭР УЛИРЛЫН АЖЛЫН ТАЙЛАН

Тээвэр хөгжлийн банкны ТУЗ-ын тогтоолоор Б.Оюунцацрал миний бие 2021 оны 4 дүгээр сарын 23-наас ТУЗ-ын хараат бус гишүүнээр томилогдон ажиллаж байна. ТУЗ-ын хараат бус гишүүний хувьд Монгол улсад мөрдөгдөж байгаа “Компанийн тухай хууль”, “Банкны тухай хууль” болон Монголбанкны Ерөнхийлөгчийн тушаалаар батлагдсан “Банкны зохистой засаглалын зарчмыг хэрэгжүүлэх журам”, “Банкны төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүнийг нэр дэвшүүлэх, томилох, чөлөөлөх журам”, “Тээвэр хөгжлийн банкны Төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагааны журам” зэргийг хэрэгжүүлэн ажилласан болно.

1. ТУЗ-ийн хуралд оролцсон байдал:

2022 оны 1 дүгээр сарын 01-ний өдрөөс 2022 оны 3 дугаар сарын 31-ны өдрийг хүртэлх хугацаанд Төлөөлөн удирдах зөвлөлийн ээлжит бус нийт 4 хурал зарлагдснаас хараат бус гишүүний хувьд бүх хуралд 100% ирцтэйгээр дараах асуудлуудыг шийдвэрлэхэд саналын эрхтэй оролцсон байна. Үүнд:

- Банкны чанаргүй активыг бууруулах 2022 оны стратеги төлөвлөгөөтэй танилцаж төлөвлөгөөг Монголбанкинд хүргүүлэхийг үүрэг болгосон.
- Дотоод аудитын газрын 2022 оны ажлын төлөвлөгөөтэй танилцаж зарим нэмэлт өөрчлөлтийг тусгаж хавсралтаар батлахаар шийдвэрлэсэн.
- Хүний нөөц, цалин урамшууллын хорооны журмыг шинэчлэн батласан.
- Эрсдэлийн аппетитийн мэдэгдэлд нэмэлт өөрчлөлт оруулан, шинэчлэн батласан.
- Банкны бүтэц зохион байгуулалт, орон тоонд нэмэлт өөрчлөлт оруулан 2022 оны 02 дугаар сарын 22-ны өдрөөс үйл ажиллагаандаа мөрдөж ажиллахыг Гүйцэтгэх захиралд үүрэг болгосон.
- Хөндлөнгийн аудитын байгууллагын тайланг бэлэн болмогц Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг зарлан хуралдуулж, холбогдох шийдвэрийг гаргуулахаар шийдвэрлэсэн.
- Банкны ТУЗ-ийн дарга, гишүүдийн гэрээний хугацааг сунгах, банкыг ХК болгож өөрчлөн байгуулах асуудлыг хэлэлцүүлэх ХЭХ-ыг зарлан хуралдуулахаар шийдвэрлэсэн.
- Муу зээлийн барьцаанд хураагдсан үл хөдлөх эд хөрөнгийг худалдан авах, үнэ тогтоох асуудлыг Хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцүүлэхээр шийдвэрлэсэн.
- Төлөөлөн удирдах зөвлөлийн 2021 оны үйл ажиллагааны тайланг Хувьцаа эзэмшигчдийн хуралд танилцуулж хэлэлцүүлэхээр шийдвэрлэсэн.
- Эрсдэлийн аппетитийн мэдэгдэлийн хавсралт №1-ийн 4.3.1-т /арилжаатай холбоотой хязгаар /нэмэлт өөрчлөлт оруулан шинэчлэн батлахаар шийдвэрлэсэн.
- ТУЗ-ийн ажлын албаны даргаар Ч.Баярмааг 2022.03.21-ний өдрөөс эхлэн томилохоор шийдвэрлэсэн.
- Банкны Тогтворжуулах төлөвлөгөөг хавсралтаар баталсан.

- Монголиан каар маркет ХХК-д 7.0 тэрбум төгрөгийн эргэлтийн хөрөнгийн зээлийг жилийн 15.6% хувийн хүүтэй, 36 сарын хугацаатайгаар олгохоор шийдвэрлэсэн.]

2. Аудитын хороонд ажилласан тухай:

Аудитийн хороо нь 2022 оны 1 дүгээр сарын 01-ний өдрөөс 2022 оны 3 дугаар сарын 31-ны өдрийг хүртэлх хугацаанд 2 удаа хуралдсан бөгөөд Аудитийн хорооны даргын хувьд дараах асуудлуудыг шийдвэрлэхэд саналын эрхтэй оролцсон. Үүнд:

- Комплаенсын газрын үйл ажиллагаанд хийсэн шалгалтын тайлантай танилцаж банкны гүйцэтгэх удирдлага болон Дотоод аудитийн газарт үүрэг даалгавар өгсөн.
- Зайны хяналтын албаны үйл ажиллагааны тайлантай танилцаж холбогдох мэдээллийг авсан.
- Дотоод аудитийн газрын 2021 оны ажлын тайлантай танилцаж 2022 оны ажлын төлөвлөгөөг ТУЗ-ын хурлаар батлуулахаар болсон.
- Дотоод аудитын газраас Гүйцэтгэх удирдлагын үйл ажиллагаан дахь хяналтыг сайжруулах, гарсан зөрчил дутагдалтай холбоотой журмын дагуу холбогдох арга хэмжээ авах саналаа хүргүүлж биелэлтэнд хяналт тавьж ажиллах үүрэг даалгавар өгсөн.
- Гүйцэтгэх удирдлага, Хүний нөөцийн газрын зүгээс зөрчил дутагдал гаргасан албан тушаалтанд хуулийн дагуу хариуцлага тооцож, хариуцлагын систем тогтоож, холбогдох арга хэмжээг цаг тухай бүрт нь авдаг болох, авсан арга хэмжээний талаар ТУЗ-ийн дэргэдэх Хүний нөөц цалин урамшууллын хороонд улирал бүрт тайлагнах үүрэг өгсөн.
- Хүний нөөцийн газраас ажилчдын сургалтын уялдаа холбоог сайжруулахад анхаарах, шинээр ажилд авч буй ажилтнуудаас шалгалтыг авч холбогдох журмын дагуу ажилд шалгаруулж авдаг байх талаар үүрэг өгсөн.

3. Эрсдэлийн удирдлагын хороонд ажилласан тухай:

Эрсдэлийн удирдлагын хороо нь 2022 оны 1 дүгээр сарын 01-ний өдрөөс 2022 оны 3 дугаар сарын 31-ны өдрийг хүртэлх хугацаанд 1 удаа хуралдсан бөгөөд ЭУХ-ны гишүүний хувьд дараах асуудлуудыг шийдвэрлэхэд саналын эрхтэй оролцсон. Үүнд:

- Эрсдэлийн удирдлагын үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилттэй танилцаж хэрэгжилтийг бүрэн хангах арга хэмжээ авч явуулах талаар зөвлөмж өгсөн.
- Эрсдэлийн нэгдсэн тайлантай танилцаж банкны санхүүгийн эрсдэл, санхүүгийн бус эрсдэл, хөрвөх чадварын эрсдэл, зээлийн эрсдэл, зах зээлийн эрсдэл тус бүрээр хийсэн үнэлгээ дүгнэлттэй холбоотой мэдээлэлтэй танилцаж цаашид анхаарч ажиллах асуудлуудын талаар санал солилцсон.
- Эрсдэлийн аппетитийн мэдэгдэлд орох холбогдох өөрчлөлтийг ТУЗ-ийн хурлаар хэлэлцэж шийдвэрлүүлэхээр болов.

Тайлан бичсэн:

ТУЗ-ын хараат бус гишүүн



Б.Оюунцацрал